

ХОВД АЙМГИЙН КАЗАХ УГСААТАН БОЛОН ӨӨЛД ЯСТНЫ ХҮҮХДИЙН БИЕ БЯЛДРЫН ӨСӨЛТ ХӨГЖЛИЙН СУДАЛГААНЫ ЗАРИМ ДҮНГЭЭС

О.Бямбадорж

Монгол Улсын Их Сургууль, Ховд дахь салбар сургууль, Биологийн тэнхим

Түлхүүр үз: экологи, казах, өөлд, хүүхдийн өсөлт хөгжил, антропометр

Эволюци хөгжлийн явцад тухайн экологийн орчинд байгалийн шаалгарлаар төлөвшин тогтсон бие эрхтний морфологи хэмжээ аливаа ястайн, үндэстэн бүрт харилцан адилгүй, өөр өөрийн өвөрмөц онцлогтой байдаг бөгөөд байгаль газар зүйн янз бүрийн бус нутагт амьдардаг хүмүүсийн бие бялдар, эд эрхтний дасан зохицох шинжүүд нь бүр хүүхэд ахуй үед нь ажиглагддаг байна /Алексеева, 1986/.

Хүүхдийн бие махбодийн өсөлт хөгжилтийн судалгаа нь онолын болон практикийн хувьд сонирхол татсан асуудал байсан бөгөөд одоо ч байсаар байна. Ийм учраас энэ асуудалд бүр антропологич Кетлегээс эхлээд орчин үеийн янз бүрийн орны / Сейзов, 1953; Шао-Линь, 1957; Волянский, 1958; Бенуа, 1960; Иосимура, 1960; Властовский, 1984; Мюллер, 1984; Prokerek, 1984; Tanner 1986; Миклашевская и др., 1988/ олон судлаачид анхаарлаа хандуулан энэ чиглэлийн судалгаа явуулж ирлээ. Харин монгол хүүхдийн бие бялдрын өсөлт хөгжилтийн судалгааг 1960 оноос хийж эхэлсэн бөгөөд сургуулийн өмнөх болон сургуулийн насны хүүхдийн биеийн үндсэн үзүүлэлтүүдийн хэвийн хэмжээг нас хүйсээр нь ангилан тогтоожээ.

Сүүлийн жилүүдэд экологийн янз бүрийн бус нутгуудад амьдардаг хүүхдийн бие бялдрын өсөлт болон хотжилтын орчин дахь хүүхдийн бие бялдрын өсөлтийн талаар судалгаа нилээд хийгдэж байна. Эдгээр судалгаанууд гол төлөв төвийн районуудад халх ястан хүүхдүүд дээр хийгдсэн байдаг.

Харин хүүхдийн бие бялдрын өсөлт хөгжилтийг монгол орны угсаатан, ястны талаас авч үзэн тэдний соёл, зан заншил, өв уламжлалтай нь холбон судалсан судалгааны ажил одоохондоо хараахан хийгдээгүй юм. Иймээс баруун монголын олон ястны өлгий болох Ховд аймгийн угсаатан, ястны хүүхдийн биеийн галбир төрх түүний өөрчлөлт, биеийн хэсгүүдийн харьцааг тогтоох зорилгоор энэхүү судалгааг явуулсан юм.

Судалгааны материал арга зүй

Бид судалгаандаа олон ястны өлгий Ховд аймгийн байгаль цаг уурын бараг ижил нөхцөлд зэргэлдээ суманд амьдардаг монгол угсаатны өөлд ястан (Эрдэнэбүрэн сум), казах угсаатан (Ховд сум) хоёрыг сонгон авсан юм. Тэдний амьдардаг нутаг далайн төвшнөөс дээш 1182-4208 орчим метрийн өндөрт өргөгдсөн голын хөндий, тал хоолой өндөр уулсаас бүрдэнэ. Цөлжүү хээр, цөлийн хээрийн бусэд оршдог, зундаа халуун хуурай уур амьсгалтай нутаг юм. Цаг уурын хувьд эрс тэс уур амьсгалтай, өвөлд уулархаг газраараа дулаавтар, хээр талдаа - 40°C хүртэл хүйтэн, сард дунджаар 12-18 мм хур тунадастай.

Судалгаанд тухайн суманд сүүлийн жилүүдэд тогтвортой амьдарч буй угуул угсаатан ястан хүүхдүүдийг хамрууллаа. Хэмжилтэнд хамрагдах хүүхдийг түүврийн аргаар санамсаргүй байдлаар сонгож авсан юм. Бидний судлагаанд 9-18 насны 131 эрэгтэй, 139 эмэгтэй бүгд 270 өөлд, мөн насны 150 эрэгтэй, 146 эмэгтэй бүгд 296 казах хүүхэд хамрагдлаа.

Антропометрийн хэмжилтийг нийтээр зөвшөөрсөн арга зүйн (Бунак, 1941) дагуу явуулав.

Энэхүү материалыа математик-статистикийн аргаар боловсруулан үр дүнг нас хүйсээр ангилан графикуудыг байгууллаа.



Судалгааны үр дүн хэлцэмж

Судалгаанд хамрагдсан угсаатан, ястны хүүхдүүдийн морфологийн үзүүлэлтүүдийг зургаар үзүүлэв.

Биеийн жин Жингийн хамгийн их нэмэгдэх нас нь охидод 13 насанд 5-5.3 кг-аар, хөвгүүдэд 15 насанд 5.5-6.5 кг-аар нэмэгддэг байна /Морфология человека, 1983/.

Бидний судалгаагаар 9-17 насны хүүхдийн биеийн жингийн дундаж өөлд ястан хөвгүүдийнх 22,61-53,45 кг, охидынх нь 21.15-50.21 кг байна. Хөвгүүд 9-11 насандаа охидоос илүү байна. Охид нь 12-16 насандаа 2.12-4.95 кг- аар их байснаа 17 насандаа буурч байна. Хөвгүүдийн биеийн жингийн огцом өсөлт 13-15 насанд харин охидынх 11-12 насанд байна.

Казах угсаатан 8-17 насны хүүхдийн биеийн жингийн дундаж хөвгүүдийнх 21.4-54,76 кг, охидынх нь 22.59-53.12 кг байна. Хөвгүүд 8-10 насандаа охидоос 0.8-1.51 кг аар илүү байна. Охид нь 11-15 насандаа 2.33-6.47 кг- аар их байснаа 16 насандаа буурч байна. Хөвгүүдийн биеийн жингийн эрчимтэй өсөлт 12-14 насанд, харин охидынх 10-13 насанд байна.





Биеийн өндрийн хэмжээ. Сүүлийн үеийн судалгаагаар хүний өндрийн өсөлт эмэгтэйд 16-17 насанд, эрэгтэйд 18-19 насанд үндсэндээ зогсдог болохыг тогтоогоод байна. 17-19 наснаас 60 насны хооронд биеийн өндөр өрөнхийдээ тогтвортой байдаг ба 60 наснаас эхэлж биеийн өндөр 5 жил дутам 0.5-1 см-ээр багасдаг байна.

Бидний судалгаанд хамрагдсан 9-18 насны өөлд ястан хүүхдүүдийн хувьд биеийн өндрийн дундаж үзүүлэлт хөвгүүдэд 122-163.83 см, охидод 119.85-155.72 см байна. 9-10 насанд хөвгүүд өндөр, 11-13 насанд охид, харин 14 наснаас эхлэн дахин хөвгүүд өсөлтийн хувьд гүйцэж байна.

Судалгаанаас харахад өөлд ястан охидын эрчимтэй өсөх нас 10-13, хөвгүүдийнх 12-14 байна.

Судалгаанд хамрагдсан 8-17 насны казах угсаатан хөвгүүдийн биеийн өндрийн дундаж үзүүлэлт 121.3-163.83 см, охидынх 119.8-158.8 см байна. 8-11 насанд хөвгүүд охидоосоо 0.5-3 см, 12-14 насанд охид 1.6-4.1 см өндөр байна. 15 эхлэн хөвгүүд дахин охидоосоо өндөр болж байна. Зураг 26- аас харахад казах хөвгүүдийн эрчимтэй өсөх нас 12.15 охидынх 10-13 байна.



Цээжний бүслүүр. Өөлд хөвгүүдийн цээжний бүслүүрийн хэмжээ 9-18 насанд 60.87-84.3 см, охидынх 57.5-82.1 см байна. Цээжний бүслүүрийн эрчимтэй

өсөх нас охидод 10-15, хөвгүүдэд 14-16 байна. Охидын цээжний бүслүүр хөвгүүдийн цээжний бүслүүрээс 12-16 насанд илүү байгаа нь зураг 1в ээс харагдаж байна.

Казах хүүхдүүдийн хувьд хөвгүүдийн цээжний бүслүүрийн хэмжээ 8-17 насанд 59.13-80.4 см, охидынх 58.67-79.1 см байна. Охидын цээжний бүслүүр хөвгүүдийн цээжний бүслүүрээс 12-16 насанд илүү байна

Дүгнэлт

1. 9-17 насны хүүхдийн биеийн жингийн дундаж өөлд ястан хөвгүүдийнх 22.61-53.45 кг, казах 21.4-54.76 кг, өөлд охидынх нь 21.15-50.21 кг, казах 22.59-53.12 кг тус тус байна. Хөвгүүдийн биеийн жингийн эрчимтэй өсөлт өөлдөд 13-15 насанд, охидынх 11-12 насанд байна. Харин казах хөвгүүдийнх 12-14 насанд, охидынх 10-13 насанд байна. Биеийн жингийн хувьд казах хөвгүүдийн биеийн жин эхлээд 1.21 кг бага байснаа 17-18 насанд 1.31 кг илүү гарч байна. Охидынх 17-18 насанд мөн илүү (2.92 кг) байна.

2. 9-18 насны хүүхдүүдийн хувьд биеийн өндрийн дундаж үзүүлэлт өөлд хөвгүүдэд 122-163.83 см, охидод 119.85-155.72 см, казах хөвгүүдийн биеийн өндрийн дундаж үзүүлэлт 121.3-163.83 см, охидынх 119.8-158.8 см байна. Өөлд ястан охидын эрчимтэй өсөх нас 10-13, хөвгүүдийнх 12-14 байхад казах хөвгүүдийн эрчимтэй өсөх нас 12-15 охидынх 10-13 байна.

3. Хөвгүүдийн цээжний бүслүүрийн хэмжээ 9-18 насанд өөлдийнх 60.87-84.3 см, охидынх 57.5-82.1 см, казах 59.13-80.4 см ба 58.67-79.1 см байна. Цээжний бүслүүрийн эрчимтэй өсөх нас ойролцоо байна.

4. Дээрх 4 үндсэн үзүүлэлтээс харахад өөлд ястан, казах угсаатан 2-ын хүүхдийн бие бялдрын өсөлт хөгжилтөнд онцын ялгаа байхгүй нь ажиглагдаж байна.

Ном зүй

Алексеева. Т.И. Адаптивные процессы в популяциях человека, 1977

Бунак В.В. Антропометрия. Москва. 1941.

Морфология человека. Под ред. Чтецова, Москва. 1983

Монгол хүний хөгжлийн илтгэл. УБ. 1997.

Монгол улсын угсаатны зүй .УБ. 1996.

Намсрайнайдан Л. Монгол хүний биеийн хэмжил зүйн лавлах. УБ. 1972.

Нямдорж Я. Говь тайгын хүн амын бие бялдар, физиологийн зарим. үзүүлэлтийн харьцуулсан судалгаа. Монгол хүн судлал. УБ. 1995.

Очир А., Дисан Т. Монгол улсын өөлдүүд. УБ. 1999.

Уранчимэг Ш. Улаанбаатар хотын охид хөвгүүдийн бие бялдрын өсөлт хөгжлийн онцлог. Монгол хүн судлал. УБ. 1995.

Уранчимэг Ш. Шилжилтийн насны монгол хүүхдийн бие бялдрын өсөлт хөгжлийн онцлог. МУИС-ийн НУФ-ийн "Эрдэм шинжилгээний бичиг". №187 (13) УБ, 2002.

Эрдэнэ М. Монгол орны тайгын бүсийн хүүхдийн морффизиологийн судалгааны зарим дүнгээс. Монгол хүн судлал. УБ. 1995.

Эрдэнэ М. Говь, тайгын бүсийн хүүхдүүдийн морффизиологийн харьцуулсан судалгаа. МУИС-ийн НУФ-ийн "Эрдэм шинжилгээний бүтээл". №3 /127/ УБ, 1997.

Summary

O.Byambadorj

Growth and development of Mongolian children of different ethnic groups

Growth changes in stature, weight and chest circumference of two ethnic groups were studied: Kazah (n=296) and Ould n=270) ethnic minority. The subjects were school children aged 8 through 18 years who lived in rural communities Erdeneburen, Khovd soums, Khovd aimag, Western Mongolia. Results of the study show not significant differences in the growth and development of children from different ethnic groups.